

дээрхи байгууллага нь дор дурдсан чиглэлээр **мэргэжлийн өндөр түвшний чадварлаг ажилтнуудыг дэмжин хамтарч ажиллаж байна:**

## СОЁЛ ХООРОНДЫН ХАРИЛЦААНЫ ТУСЛАХ

## СОЁЛ ХООРОНДЫН ХАРИЛЦААНЫ ЗУУЧЛАГЧ

## СОЁЛ ХООРОНДЫН ХАРИЛЦААНЫ ХЭЛМЭРЧ

### ГЭЖ ЯМАР ХҮНИЙГ ХЭЛЭХ ВЭ?

- Гадаадын иргэдийг Чех Улсын албан байгууллагуудтай харьцахад туслах, шаардлагатай асуудлыг нь хөөцөлдөж бүтээж, орчуулга хийх, улмаар шүүхийн өмнө тэднийг төлөөлөх гэх мэт туслалцаа үзүүлдэг олон хүн байдаг
- Гэвч тэдгээрийн дотор жинхэнэ мэргэжлийн хүн маш цөөхөн байдаг юм.

**Соёл хоорондын харилцааны чадварлаг мэргэшсэн хэлмэрч, зуучлагч, туслах ажилтан нь ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх чадвартай, тус мэргэжлийн чиглэлээр зохих сургалт дүүргэсэн хүмүүс байдаг.**

- Мэргэжлийн бус, чадвар тааруу хэлмэрч, зуучлагч хөлсөлснөөс урган дараахь бэрхшээл үүсч болох талтай. Үүнд,
- өөрийнх нь хэрээс хэтэрсэн биелүүлэх боломжгүй зүйл амлах,
  - таны хэргийг бүтээх хэдий ч түүнээс урган гарч болох эрдсэл, үүрэг, мөн цаашид зайлшгүй хийх шаардлагатай зүйлийг хэлж сануулахгүй анхаарлын гадна орхих,
  - таны хэрэг явдлыг хууль бус аргаар нааштай бүтээх,
  - баримт бичгийн эх хувилбарыг нь аваад буцааж өгөхгүй байх,
  - шүүх хурлын явцад буруу ташаа орчуулга хийж, өөрийн тань хэлснийг бусдад үл ойлгогдох хүртэл гуйвуулах,
  - буруу ташаа мэдээлэл өгсөн тохиолдолд тэр нь эргээд тантай холбоотой асуудал маргааныг хэлэлцэж, шийдвэрлэхэд сөрөг нөлөө үзүүлэх.

Үйлчилгээ үзүүлснийхээ төлөө хөлс авч байгаа этгээдийн мэдлэг, чадвар зохих хэмжээнд байгаа эсэхийг зуучлагч, хэлмэрч хөлсөлж байгаа хэн боловч шалгаж магадлах нь зүйтэй.

## СОЁЛ ХООРОНДЫН ХАРИЛЦААНЫ ХЭЛМЭРЧ ГЭЖ ХЭНИЙГ ХЭЛЭХ ВЭ?

Сайн орчуулга хийхийн тулд ямар мэдлэг эзэмшсэн байх шаардлагатай вэ?

- чех хэлээр чөлөөтэй ярих
- хууль зүйн чех хэний мэдлэг сайтай байх
- хоёрдахь гадаад хэлээр чөлөөтэй ярих
- хоёрдахь гадаад хэлний хувьд хууль зүйн хэл бага зэрэг ч болов эзэмшсэн байх
- гадаад хэл мэддэг хүн бүр орчуулагч болдоггүй, **хэлмэрчлэх чадварыг сайтар эзэмшиж байж орчуулга хийнэ**
- хэлмэрч этгээд нь орчуулж буй асуудалд хувийн ашиг сонирхлын үүднээс хандах, санаатай худал эсвэл буруу ташаа орчуулахыг хориглоно
- оролцогч талуудын хэлж байгаа зүйлийг үнэн зөв, яг байгаагаар нь орчуулах ёстой
- орчуулж буй зүйлд ямар нэгэн өөрчлөлт оруулж, хувиасаа тайлбар нэмэхийг хориглоно
- нэмэлт тайлбар хийх шаардлагатай гэж үзвэл зохих хүмүүст энэ тухайгаа урьдчилан мэдэгдэх
- Чех Улсын нөхцөл байдлыг сайтар ойлгож мэдэх
- Чехийн төрийн, орон нутгийн болон бусад байгууллагын талаар мэдлэг, мэдээлэл сайтай байх
- тухайн гадаадын иргэдий төрсөн нутгийнх нь нөхцөл байдлын талаар мэдлэг, мэдээлэл сайтай байх
- БНЧех Улсад гадаадын иргэд оршин суух тухай хуулийн талаар ойлголт сайтай байх.

Хүүхэд наснаасаа тус улсад амьдарч байгаа оюутан эсхүл олон жил орчуулгын ажил хийж байгаа туршлагатай хүн шууд л соёл хоорондын харилцааны сайн хэлмэрч болно гэж ойлгох нь учир дутагдалтай юм. Гадаадын иргэд, цагаачид, онцлог бүхий бусад бүлэг хүмүүст орчуулга хийлгүүлэхээр тусгайлан бэлтгэсэн хүмүүсийг **соёл хоорондын харилцааны мэргэшсэн хэлмэрч** эсвэл **нийгмийн хэлмэрч** гэх бөгөөд эдгээр хүмүүс нь мэргэжлийн болон шалгалтын гэрчилгээ эсвэл нэр хүнд бүхий байгууллагаас олгосон сайшаалын үнэлэлттэй байна.

## СОЁЛ ХООРОНДЫН ХАРИЛЦААНЫ ТУСЛАХ ГЭЖ ХЭНИЙГ ХЭЛЭХ ВЭ?

Ямар мэдлэг чадвар эзэмшсэн тохиолдолд бусдад үр өгөөжтэй тусалж болох вэ?

- дээр дурдсан мэдлэг чадвараас гадна доорхи мэдлэг чадвар эзэмшсэн байна. Үүнд,
- орчуулж байгаа зүйлээ тайлбарлах,
- харилцаа, хэлэлцээ, маргааныг хэрхэн шийдэх аргын талаар үндсэн ойлголттой,
- соёл хоорондын ялгааг сайн мэдэхээс гадна бусдад энэ талаар ойлгуулах чадвартай,
- хууль зүйн болон БНЧех Улсад гадаадын иргэд оршин суух тухай хуулийн талаархи үндсэн мэдлэг сайтай,
- нийгмийн ажлын үндсэн аргачлалд мэргэшихээс гадна анх удаа ярилцлаганд орж байгаа хүмүүсийн яриаг хөтлөж чиглүүлэх, нийгмийн тусалцааны аргачлал, нийгэм болон сэтгэл зүйн судлал, бэрхшээлийг даван туулахад үзүүлэх тусалцаа зэргийн талаар үндсэн мэдлэгтэй байх шаардлагатай.

Соёл хоорондын харилцааны туслах ажилтан нь дээрхийн адил мэргэжлийн гэрчилгээ, сайшаалын үнэлэлт зэрэг үнэмлэх эзэмшсэн байна. Мэргэжлийн гэрчилгээ, сайшаалын үнэлэлттэй ажилтнуудын хувьд эмнэлэг, ашгийн бус болон төрийн байгууллагуудад (БНЧУ-ын ДХЯ) ажиллах боломж өргөн нээлттэй. Ингэж ажиллаж байгаа тохиолдолд тус мэргэжилтнийг тухайн байгууллагын үндсэн чиглэлээр буюу эрүүл мэнд, стритворк, нийгмийн ажил, хууль эрх зүй гэх мэт салбарт давхар мэргэшүүлдэг. **Чех Улсын зарим байгууллагууд соёл хоорондын харилцааны мэргэжлийн туслах ажилтныг нэгэнт ажилуулж эхэлсэн бөгөөд шаардлагатай тохиолдолд эдгээр байгууллагад хандаж тэдний үйлчилгээг авч болно.**

## СОЁЛ ХООРОНДЫН ХАРИЛЦААНЫ ЗУУЧЛАГЧ ГЭЖ ХЭНИЙГ ХЭЛЭХ ВЭ?

Ямар мэдлэг чадвар эзэмшсэн тохиолдолд бусдад үр өгөөжтэй тусалж болох вэ?

- дээр дурдсан мэдлэг чадвараас гадна доорхи мэдлэг чадвар эзэмшсэн байна. Үүнд,
- Зарим нэг өвөрмөц маргааныг таслан шийдвэрлэх чиглэлээр тусгайлан мэргэшсэн байх:
  - соёлын ялгаатай орчинд төрж өссөн хүмүүсийн хооронд үүссэн маргаан
  - соёлын ялгаатай орчинд төрж өссөн бүлэг хүмүүсийн хооронд үүссэн маргаан
  - нутаг нэгт хүмүүсийн дунд үүссэн маргаан.
  - хэлэлцэх чадвар
  - маргааныг таслан шийдвэрлэхэд зуучлах чадвар
  - бусдыг эрчимжүүлэх чадвар
  - хэлмэрч, соёл хоорондын харилцааны туслахтай хамтран ажиллах чадвар,
  - тухайн орнуудын соёл, нөхцөл байдлын талаар ойлголт сайтай байх

Соёл хоорондын харилцааны зуучлагч нь гадаадын иргэдийн чехийн нийгмийн дийлэх хэсэгтэй мөн чех албан газраас гадаадын иргэдтэй харьцах харьцаанд гарч болзошгүй үл ойлголцох явдлаас сэргийлэхэд гол анхаарлаа хандуулж ажиллана. **Талууд бие биенийгээ сайтар ойлголцсоны үндсэн дээр тохиромжтой хариу үйлдэл хийх хүртэл нь зуучлагч шаргуу туслах үүрэгтэй.** Соёл хоорондын харилцааны зуучлагчдыг албан газар, байгууллага, оршүүдийн хооронд үүссэн (удаан үргэлжилж буй) маргааныг шийдвэрлэх асуудалд оролцуулах нь үр дүнтэй байдаг. Соёл хоорондын харилцааны зуучлагч нь мэргэжлийн гэрчилгээ, сайшаалын үнэлэлт зэрэг үнэмлэх эзэмшсэн байна.

Дээрхи нэр томьёо нь Чех Улсад албан ёсоор мөрдөгдөж эхлээгүй, шинээр нэвтрүүлж буй нэг томьёо юм. Дээр нэр дурдсан мэргэжилтний орчуулга, зуучлалын үйлчилгээ нь Танд найдвартай үйлчилгээ, тусалцаа үзүүлж, үйлчлүүлэгчийн эрхээ эдлэх аливаа тохиолдолд багагүй хувь нэмэр болох болно.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахын тул klubhanoi@klubhanoi.cz гэсэн хаягаар хандана уу

Шуудангийн хаяг: Klub Hanoi, Černého 426, 182 00 Praha 8

Офис: „САПА“ барааны зах (үүдний жижүүрийн дэргэдэх саарал өнгийн байрны 6 давхарм), Libušská 319, Praha 4 – Písnice  
Нийтийн тээврийн хэрэгслээр манай офисд ирэх бол 113, 333, 198, 197, 331 номерийн автобусаар явж „Sidiště Písnice“ буудалд бууна уу.  
Зөвхөн лхавга гаригт ажиллана. Ажлын бусад цагт уулзах тохиолдолд дээрхи цахим шуудангийн хаягаар хандаж урьдчилан тохиролцоно уу.

Мөнгөн тусламж, хандивыг тус „Клуб Ханой“-н дансанд илжүүлсэн Танд баярлалаа: 2105343359/0800; IBAN CZ41 0800 0000002105343359.